

## ТӨВДИЙН ОРШУУЛГЫН ЁС

Эдгэршгүй өвчтэй хүнийг амьсгаа хураахаас өмнө ухаанаа алдаагүй байхад нь ойр төрлийн хүн нь гэрээсийг нь авдаг. Өвчтөний ор дэвсгэрт ямарваа нэгэн араатан амьтны арьс байвал яаралтай авдаг байна. Энэ нь шашны зан үйлтэй холбоотой бөгөөд араатан амьтны арьс хөрс биенд нь хүрч байвал нас барах гэж буй хүний хойд насны уншлага үйлдэхэд саадтай хэмээн үздэг.

Амьсгал хураахаас нь өмнө адистай үрэл, пэлдэн (нэгэн төрлийн үрэл) цэвэр усанд уусгаж уулгах юмуу эс бөгөөс шар тосонд зуурч өгдөг. Үүнээс уламжлан «Үгийн эцэс гэрээс идэхийн эцэст Пэлдэн, уухын эцэс рашаан» гэсэн зүйр үг гарчээ.

Гадуур, дотуур амьсгаа хураах гэж төвдүүд ярьдаг бөгөөд гадуур амьсгал хураагдаад дотуур амьсгалтай байхад нь ойр дотны хүмүүс нь өвчтөний чихэнд шүтдэг бурханы нэрийг нь чанга хэлдэг. Энэ үед эхнэр хүүхэд юмуу нөхрийг нь хажууд нь байлгадаггүйн учир нь тэд уйлж орилж тэр хүний бясалгалыг сарниулж болзошгүй учир нас барагчийн хойд насны сайн сайхны тусын тулд үүнийг баримталдаг ёстой байна.

Дотуур амьсгал хураагаад үхсэний нь дараа байр байдлыг нь хөдөлгөж өөрчлөхийг цээрлэдэг байна.

### Нас барсных нь дараа үйлдэх ёс

Пово-хэмээх хойд насны тухай шашны үйл ажиллагааг үйлдэхээс өмнө хэн ч цогцсонд хүрэхгүй бөгөөд талийгаачийн садан төрөл пово хийдэг ламыг гэртээ залж авчрах агаад энэ үед лам хуврагуудыг заавал авчирдаг ёстой ажээ.

Талийгаачийн дэргэд үргэлж зул асаадаг нь нэг талаар тахил, нөгөөтэйгүүр муу ад чөтгөр ойртуулахгүй байх бэлгэдэлтэй.

Гэр бүлийн хүмүүс уй гашуугаа илэрхийлж үсээ самнахгүй задгай тавьж, ээмэг бөгж зэрэг гоёлын зүйл үл хэрэглэж оршуулах ёс дуустал нүүр гараа ч угаахгүй байж хар бараан хуучивтар хувцас өмсдөг. 49 хоногийн турш дуулж хуурдан бүжиглэж найрлахыг цээрлэнэ. Талийгаачийн аяганд цай, замбай, будаа 3-ыг хийж тавьдаг ёс ч бас байдаг. Пово хийхээс өмнө цогцсонд гар хүрч үл болно. Учир нь гар хүрсэн газраас эхлэн сүнс нь гардаг, иймээс биеийн доод хэсгээр сүнс гарвал муу заяанд, дээд хэсгээр гарвал дээд заяанд төрдөг гэсэн яриа байдаг гэнэ.

### Пово гэж юу вэ?

Нас нөгчигчдийн хойд төрлийг муу заяанаас аврахын тулд сүнсийг нь хүчээр ариун оронд аваачдаг нууц тарнийн онцгой арга юм.

Аль зүгт харуулж оршуулахыг нь ламаас асууж шийднэ. Үрэл, дэлдэнг, ус юмуу шар тосонд шингэлж зан авир сайтай хүн талийгаачийн толгойны нь оройд түрхэнэ. Хайнагийн тосыг хэрэггүй гэдэг. Толгойд түрхэх үрэл Пэлдэн байхгүй бол ламыг пово уншсаны дараа талийгаачийн толгойн оройны үснээс зөөлөн татаад дараа нь биенд нь хүрвэл зүгээр. Энэ бол сүнсийг оройноос нь гаргах аргууд юм. Сэнгэнял дав-арслангийн хэвтэр гэсэн үг бөгөөд энэ хэвтрээр нас нөхчивеес повоны хэрэггүй өөрөө үйл явдлын пово болсон гэж үздэг ёстой. Нас барсан өдрийн гариг, цагийг сайн мэдэж байх ёстой бөгөөд зурхай зуруулахад маш их хэрэгтэй юм. Цогцсын дэргэд «Минтэг», «Гүнрэг» гэдэг

ном уншдаг. Зарим нэгэн хүний царай нь хэвийн хувирахгүй байж, биенээс нь үнэр гарахгүй байвал оршуулж болдоггүй бөгөөд шинж тэмдэг нь илэртэл хөдөлгөхгүй байлгах ба оршуулах өдөр нь болчихсон ч гэсэн шинж тэмдэг илрэхгүй байвал хамрынх нь ойролцоо утаа тавьж хонх, дамар цохиж, «Хажид» гэдэг бурханы ерөөлийг эгшиглэнтэйгээр уншихад шинж тэмдгээ өгч биеийн хөшөвс нь тавигдан, хамрын нүхнээс нь улаан юмуу цагаан өнгөтэй шингэн гарч, цогцосноос үнэр гардаг. Зүүн хамраас нь цагаан юм гарвал талийгаач их бясалгалчин хүн байсны шинж гэж үздэг.

Оршуулахын урьд цогцсыг дэвсэн, гүргэм, чавар зэрэг үнэртэн уусгасан бүлээн усаар сайтар угаасны дараа цэвэр даавуугаар арчина. Ам хамрын нүхээр ус оруулахыг цээрлэдэг байна. Угаалга үйлдсэнээр нохой шувуу хурдан идэх учиртай. Цогцос байгаа газар муур, нохойг оруулж огт болохгүй.

Өглөөний бар цагаас эхлэн (3-5-ын хооронд) оршуулна. Цогцсыг модон дамнуурга дээр авч явна. Ядуучууд даавуун дээр авч явдаг. Цогцосны толгой хэсэгт бурханы хөрөг зургийг тавьж болдог. Энэ нь бас хөрөнгө чинээнээсээ шалтгаална.

Хаалганы гадна сангийн утааг ихээр уугиулж 4 хүч тэнхээтэй хүн шарилыг хурдан авч гараад зурхайгаар үзүүлсэн зүг рүүгээ явахдаа санг зөв 3, буруу 3 удаа тойрч гарна. Талийгаачийн эхнэр юмуу нөхөр, үр хүүхэд, маш ойрын хүмүүс нь сүүлчийн удаа цогцсыг нь харчихаад оршуулахад явдаггүй. Сум, хадгаар араас нь даллага авдаг. Оршуулгад оролцсон хүмүүс хүжээр биеэ ариутгаад гэр гэртээ харьдаг бөгөөд тэр өдрөө талийгаачийнд очдоггүй. Хүүрийн газар очсон хүмүүсийн идэж уух юмыг нэг хүн авч явдаг. Цогцсыг залсан хүмүүст гарыг нь цайлгах юм өгдөг ба ялангуяа цогцсыг нь эвдэж шувуунд өгсөн хүнд том хэмжээний өргөл барьц өгдөг.

Хүүрийн газар ирэнгүүтээ хоол хүнс авч ирсэн хүн цай чанаж, Довдон, пүндэн хоёрт цай, замбайн гурил, мах өгнө. Хөрөнгө чинээтэй айлууд лам хуврагыг залж авчирдаг. Хагас цаг хиртэй ерөөл уншуулж өргөл өргөдөг.

Довдон— яс барьсан хүн

Пүндэн-цогцсыг тасчиж залагч

Довдон сан тавьсаны дараа талийгаачийн биеийг нь ороосон даавууг авч цогцсыг түрүүлгэнэ харуулж тавиад хурц хутгаар махыг нь хэсэг хэсгээр огтлосны дараа дээш нь харуулж мөчилж салгана.

Ихэнх оршуулгын газар 4 чулуутай байдаг. Чулуун дээр мах, ясыг нь даруулж уядаг бөгөөд энэ нь шувуу ирж идэх үед газар унагахаас болгоомжилсон хэрэг юм. Үүний дараатал бүрээс таснууд нисэн ирж тойрч суугаад махыг нь дор нь иддэг. Зарим хүүрийн газар удирдагч тас байдаг бөгөөд түүнийг маханд хүрэхээс нааш бусад нь очиж иддэггүй байна. Удирдагч тас 3—4 бөөрөнхий мах идсэний дараа бусад нь нисэн ирж дайрч шавааралдан иддэг. Таснууд тэнд байгаа хүмүүст ямар ч хорлол хүргэдэггүй учир яс барьдаг хүмүүс тасын өднөөс сугалан авч охид хүүхдүүд тоглодог (тэвэ) гэдэг тоглоом хийж зардаг байна.

Махыг нь идээд дууссаны дараа үлдсэн ясыг нь нүдэж нунтаглан тархитай нь юмуу цустай нь хольж хутган тэвшинд хийж тавьдаг. Гавлын ясыг хүнд чулуугаар дардаг, хэрэгтэй гэж үзвэл авч хадгалдаг. Зарим газар цогцсыг чандарлаж үнсийг нь суварганд хийдэг бөгөөд ихэнхдээ том лам хувилгаадыг ингэдэг байна.

Талийгаачийг оршуулсны дараахь 7, 7 хоногт нь их буян үйлддэг.

Хамгийн том буяныг 49 хоног дээр нь үйлддэг ба лам хуврагуудыг залж авчран ном хурал уншуулж, бурхан бүтээдэг. Гашуудах ёслолд оролцсон хүмүүст цай хоол өгч цайлан, бие сэтгэлийн алжаал тайлан хурим хийдэг. Энэ үед «Додьгалсан» гэдэг өлзий бэлгэдэлтэй номыг уншдаг. Цайллагад оролцсон хүмүүст гар цайлгах юм гэж гашуудал тайлдаг.

Энэхүү ёсыг үйлдэхэд айл бүл хөрөнгө чинээндээ тохируулан үйлддэг байна. Жилийн дараа том тахилга хийдэг нь нас нөгчөгчийг хойд төрөл олсонд зориулж найз нөхөд, лам хуврагуудыг авчирч тахил бурханаа дэлгэн тавиад ерөөл магтаал хэлж, тахилгын ном уншдаг. Чинээлэг нэг нь хийдэд очиж, ном уншуулж өргөл барьц барьдаг.

Цай хоол ууж идэж дуу дуулж баясгалангийн хурал хуруулдаг. Сүүлд нь бурхандаа хадаг өргөж энэ хурим өндөрлөдөг байна.

Түвдэнсанжаа  
«Төвдийн нас барагсдын ёс»  
Драмасала, 1984  
Төвд хэлнээс орчуулсан Д. Энхтайван